



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2025/127/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: [Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com](mailto:Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 78  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН  
СУМЫН ХҮҮХДИЙН 14 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ч.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 14-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 9 арга хэмжээнд төсвөөс 730,817.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 91.6 хувь буюу 670,095.6 мянган төгрөгийг зарцуулж, 59,062.6 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 14-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 үндсэн зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 97.2 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<b>121,076,877.67</b>	<b>120,125,901.67</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	62,392,015.78	59,062,671.68
311	Кассад байгаа бэлэн мөнгө	62,392,015.78	59,062,671.68
312	Банканд байгаа бэлэн мөнгө	62,392,015.78	59,062,671.68
3121	Төгрөг	62,392,015.78	59,062,671.68
31211	Төрийн сангийн харилцах	62,392,015.78	59,062,671.68
35	БАРАА МАТЕРИАЛ	58,684,861.89	61,063,229.99
351	Түүхий эд материал	537,550.00	186,000.00
3513	Эм боох материал	537,550.00	186,000.00
354	Хангамжийн материал	58,147,311.89	60,877,229.99
3541	Бичиг хэргийн материал	1,529,600.00	1,913,600.00
3542	Аж ахуйн материал	54,948,370.89	55,749,719.89
3545	Барилгын засварын материал	1,192,000.00	2,287,100.00
3546	Хүнсний материал	477,341.00	926,810.10
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<b>61,240,782.93</b>	<b>68,067,446.05</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,240,782.93	68,067,446.05
392	Биет хөрөнгө	30,140,782.93	36,967,446.05
39201	Барилга, байгууламж орон сууц	8,421,178.75	-
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,421,178.75	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,365,839.00	56,045,308.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-43,341,274.75	-26,732,137.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,317,140.62	26,840,411.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,683,088.61	-23,118,302.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,400,000.00	4,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-95,833.33	-645,833.29
39217	Ном	178,000.00	178,000.00
393	Биет бус хөрөнгө	31,100,000.00	31,100,000.00
39301	Программ хангамж	2,417,500.00	2,417,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,417,500.00	-2,417,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	31,100,000.00	31,100,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<b>182,317,660.60</b>	<b>188,193,347.72</b>
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	182,317,660.60	186,774,347.72
3	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,419,000.00
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,419,000.00
413	Өглөг		1,419,000.00
4136	Бараа үйлчилгээний зардлын өглөг		619,000.00
4132	Бусад өглөг		800,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		800,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	182,317,660.60	186,774,347.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	31,100,000.00	31,100,000.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	151,217,660.60	155,674,347.72
5121	Өмнөх үеийн үр дүн	151,217,660.60	151,217,660.60
5122	Тайлант үеийн үр дүн		4,456,687.12
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<b>182,317,660.60</b>	<b>188,193,347.72</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	549,911,200.00	687,654,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,507,000.00	19,369,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,507,000.00	19,369,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,367,000.00	19,229,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>541,404,200.00</b>	<b>668,285,200.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,923,200.00	596,779,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	470,923,200.00	596,779,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,481,000.00	71,506,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,481,000.00	71,506,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	494,975,909.39	683,198,012.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,975,909.39	683,198,012.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,788,334.21	675,928,010.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,201,125.26	467,378,760.65
210101	Үндсэн цалин	259,105,035.04	342,046,973.65
210102	Нэмэгдэл	52,348,674.22	109,065,137.00
210104	Урамшуулал	7,747,416.00	16,266,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,140,678.18	58,193,832.35
210201	Тэтгэврийн даатгал	28,342,552.16	40,093,830.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,356,897.16	4,715,814.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,593,117.68	2,344,128.86
210204	Ажилгүйдлийн даатгал	622,553.35	2,208,868.74
210205	Эрүүл мэндийн даатгал	6,225,557.83	8,831,189.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,293,424.82	52,707,297.70
210301	Гэрэл, цахилгаан	4,556,109.82	4,974,475.00
210302	Түлш, халаалт	48,049,212.00	41,373,600.20
210303	Цэвэр, бохир ус	3,688,103.00	6,359,222.50
2104	Хангамж, бараа материалын зардал	459,719.56	
210408	Бараа материал акталсны зардал	459,719.56	
2105	Нормативт зардал	41,134,451.00	46,569,382.00
210502	Хоол, хүнс	41,134,451.00	46,569,382.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,622,000.00	16,830,800.00
210604	Урсгал засвар	7,622,000.00	16,830,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	848,200.00	1,706,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	848,200.00	1,706,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,088,735.39	32,541,737.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,324,050.00	13,101,801.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	882,180.00	4,842,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,882,505.39	14,597,736.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,187,575.18	7,270,002.30
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,611,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,611,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		1,658,902.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,658,902.30
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,187,575.18	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,187,575.18	

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>54,935,290.61</b>	<b>4,456,687.12</b>
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>54,935,290.61</b>	<b>4,456,687.12</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>541,544,200.00</b>	<b>668,425,200.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	140,000.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	140,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,404,200.00	668,285,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,923,200.00	596,779,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	470,923,200.00	596,779,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,481,000.00	71,506,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,481,000.00	71,506,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<b>483,483,644.44</b>	<b>669,559,644.10</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>483,483,644.44</b>	<b>669,559,644.10</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479,296,069.26	662,289,641.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,217,354.18	466,376,724.00
210101	Үндсэн цалин	242,354,323.82	333,328,324.00
210102	Нэмэгдэл	68,645,480.36	116,877,912.00
210104	Урамшуулал	8,217,550.00	16,170,488.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,124,449.26	59,178,400.00
210201	Тэтгэврийн даатгал	27,769,580.36	40,241,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,350,638.28	4,734,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,733,931.01	2,367,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	661,006.98	2,367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,609,292.63	9,468,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,293,424.82	52,707,297.70
210301	Гэрэл, цахилгаан	4,556,109.82	4,974,475.00
210302	Түлш, халаалт	48,049,212.00	41,373,600.20
210303	Цэвэр, бохир ус	3,688,103.00	6,359,222.50
2105	Нормативт зардал	41,531,841.00	46,417,320.10
210502	Хоол, хүнс	41,531,841.00	46,417,320.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	17,140,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	17,140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	848,200.00	1,706,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	848,200.00	1,706,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,280,800.00	18,763,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,736,300.00	13,152,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,544,500.00	5,611,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,187,575.18	7,270,002.30
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,611,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		5,611,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		1,658,902.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,658,902.30

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 14 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,187,575.18	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,187,575.18	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b>58,060,555.56</b>	<b>-1,134,444.10</b>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,000,000.00	2,194,900.00
	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.0	2,194,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.0	-2,194,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,000,000.0	2,194,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	56,060,555.56	(3,329,344.10)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,331,460.22	62,392,015.78
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,392,015.78	59,062,671.68

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	31,100,000.00		151,217,660.60	182,317,660.60
9	Тайлант үеийн үр дүн	-	-	4,456,687.12	4,456,687.12
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	31,100,000.00		155,674,347.72	186,774,347.72

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	730,817,100.00	670,095,641.80	60,721,458.20	91.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	730,677,100.00	670,095,641.80	60,581,458.20	91.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	725,066,000.00	664,484,541.80	60,581,458.20	91.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,250,400.00	466,376,724.00	48,873,676.00	90.51
210101	Үндсэн цалин	372,441,600.00	333,328,324.00	39,113,276.00	89.50
210102	Нэмэгдэл	132,054,300.00	116,877,912.00	15,716,388.00	88.51
210104	Урамшуулал	10,754,500.00	16,170,488.00	-5,415,988.00	150.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,859,400.00	59,178,400.00	1,681,000.00	97.24
210201	Тэтгэврийн даатгал	41,385,300.00	40,241,300.00	1,144,000.00	97.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,867,900.00	4,734,300.00	133,600.00	97.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,434,300.00	2,367,100.00	67,200.00	97.24
210204	Ажилгүйдлийн даатгал	2,434,300.00	2,367,100.00	67,200.00	97.24
210205	Эрүүл мэндийн даатгал	9,737,600.00	9,468,600.00	269,000.00	97.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,366,200.00	52,707,297.70	1,658,902.30	96.95
210301	Гэрэл, цахилгаан	5,479,600.00	4,974,475.00	505,125.00	90.78
210302	Түлш, халаалт	41,449,800.00	41,373,600.20	76,199.80	99.82
210303	Цэвэр, бохир ус	7,436,800.00	6,359,222.50	1,077,577.50	85.51
2105	Нормативт зардал	53,598,600.00	46,417,320.10	7,181,279.90	86.60
210502	Хоол, хүнс	53,598,600.00	46,417,320.10	7,181,279.90	86.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,140,000.00	17,140,000.00		100.00
210604	Урсгал засвар	17,140,000.00	17,140,000.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,706,200.00	1,706,200.00		100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,706,200.00	1,706,200.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,145,200.00	20,958,600.00	1,186,600.00	94.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,534,100.00	15,347,500.00	1,186,600.00	92.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,611,100.00	5,611,100.00		100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,611,100.00	5,611,100.00		100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,611,100.00	5,611,100.00		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,611,100.00	5,611,100.00		100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	730,817,100	666,766,297.70	64,050,802.30	91.24

131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	596,779,000.00	596,779,000.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	596,779,000.00	596,779,000.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,506,200.00	69,847,297.70	1,658,902.30	97.68
132001	Орон нутгийн төсвөөс	71,506,200.00	69,847,297.70	1,658,902.30	97.68
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	62,531,900.00	140,000.00	62,391,900.00	0.22
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00		100.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	62,391,900.00		62,391,900.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		62,392,015.78	-62,392,015.78	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		59,062,671.68	-59,062,671.68	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.00
610001	Төсвийн байгууллага	1	1		100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	22		100.00
6	Удирдах ажилтан	1	1		100.00
7	Гүйцэтгэх ажилтан	11	11		100.00
8	Үйлчлэх ажилтан	10	10		100.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа залруулаагүй. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 зөрчил<sup>1</sup> илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1. Албан шаардлага

3.1.1 Харилцагч байгууллагуудтай тухай бүр авлага, өглөгийн тооцоо нийлээгүйгээс жилийн эцэст 1,419.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өглөгийг барагдуулан ажиллах албан шаардлага хүргүүлээ.

#### 3.2. Зөвлөмж

Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.

**Илрүүлэлт:** Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

**Зөвлөмж:** Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өр төлбөртэй холбоотой	1	1,419.0			1	1,419.0							
Бараа материалтай холбоотой	1						1						
Дүн	2	1,419.0			1	1,419.0	1						